

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААС САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2014 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ

2015.02. 25

№	Аудитын шалгалтын зөвлөмж	Биелэлт /2014 оны эцсийн байдлаар/
1	<p align="center">Төсвийн төлөвлөлтийн талаар</p> <p>2014 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зардлыг Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын дагуу зардлын бүлэг хооронд хэтрүүлээгүй боловч унаа хоолны хөнгөлөлтийн зардлыг 47.2 сая, улсын байцаагчийн урамшууллын зардлыг 22.2 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн. /Төсвийн тухай хууль 6 дугаар зүйл 4.1 -ийг баримтлах/</p>	<p>2014 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт цалингийн сан 1 476 089.8 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1 476 024.2 мянган төгрөг болж 65.6 мянган төгрөгөөр хэмнэсэн ба үндсэн цалин 16 4945.0 мянган төгрөгийн хэмнэлттэй, нэмэгдэл цалин 68736.8 мянган төгрөг, хоол унааны зардал 96 142.5 мянган төгрөгийн хэтрэлттэй байгаа боловч бүлэг хооронд төсөв хэтрүүлээгүй.</p>
2	<p>Ажлын албаны даргын 2014 оны 4-6 дугаар сарын 83, 100, 125, 168 дугаар тушаалаар тухайн сард цалинтай чөлөө авсан байцаагч нарын урамшууллын 706.0 мянган төгрөгийг бүрэн олгосон. СЗХ-ны 2006 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Улсын байцаагчийн эрхтэй хянан шалгагчид урамшуулал олгох журам"-ын 2.2-ыг баримтлан ажиллах</p>	<p>Аудитын шалгалтаар нэр бүхий 4 ажилтанд чөлөөтэй байсан хугацаанд улсын байцаагчийн нэмэгдэл 706.0 мянган төгрөгийг илүү олгосон зөрчил илэрснийг 2014 оны 7 -11 дүгээр сарын цалингаас суутган тооцож барагдуулсан. /Жагсаалтыг хавсаргав/</p>
	Өглөгийн талаар	

<p>3,4</p>	<p>2014 оны эхний хагас жилийн өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлд өглөгийн үлдэгдлийг хасах 1403.5 сая төгрөгийг залруулан бүртгэж. НББ-ийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-ийг баримтлан ажиллах</p> <p>5.9 сая төгрөгийн өглөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй. НББ-ийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-ийг баримтлан ажиллах</p>	<p>2014 оны эхний хагас жилийн байдлаарх 36 байгууллага, хүмүүстэй холбоотой өглөгийн үлдэгдэл 165 395.8 мянган төгрөгийг холбогдох газруудтай тооцоо нийлж, урд онуудын үндсэн баримтуудыг хуулбарлан, зарим нэг байгууллагын нэр дээр нэмэх, хасах үлдэгдэлтэй өглөгийг залруулан хаалтын бичилт хийсэн.</p> <p>Нэг байгууллага, хүмүүсийн тооцоо 2 өөр дансанд өөр өөр кодтой нээснээс үүссэн өглөг авлагын үлдэглийг хааж залруулах бичилт хийсэн.</p> <p>2010 оноос хойш үүссэн зохицуулалт үйлчилгээний орлого, тэмдэгтийн хураамжийн орлоготой холбоотой өглөгийн тооцоог холбогдох баримтыг үндэслэн орлогын дансанд хаалтын бичилт хийж өглөгийн үлдэгдлийг бууруулснаар 6 байгууллагад 20 530.7 мянган төгрөгийн өглөгтэй байна.</p> <p>Эхний хагас жилийн өглөгийн үлдэгдэл 144 865.1 мянган төгрөг буюу 87.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Дээрхи 4 байгууллагаас Газар партнерс ББСБ байгууллагатай холбоотой улсын тэмдэгтийн хураамж 33.0 мянган төгрөг, Сангийн яаманд төвлөрүүлэх торгуулийн өглөг 500.0 төгрөгийг 2015 онд улсын төсөвт төвлөрүүлэн хаах ба Азия пасифик секюритис ХХК-тай холбоотой 750.0 мянган төгрөгийн өглөг нь тухайн зохицуулалт үйлчилгээ хийх зөвшөөрөл гараагүйтэй холбоотой үүссэн тул үлдэгдлийг 2015 оны зохицуулалт үйлчилгээний хураамжаас хасч тооцох замаар барагдуулна.</p> <p>Төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан</p>
------------	---	---

		<p>үүссэн хувь хүний орлогын албан татварын өглөг 7685,4 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 11535,3 мянган төгрөг, нийт 19220,7 мянган төгрөгийн өглөг шинээр үүссэн.</p>
	<p>Авлагын талаар</p>	
<p>5</p>	<p>Шатахууны мөнгө шилжүүлснээр "Петровис" ХХК-иас авлага үүсгэж, жолоочийн карт цэнэглэсэн хэмжээгээр тус компанийн авлагыг хорогдуулж, жолоочоос авах авлагыг нэмэгдүүлсэн дансны бичилт хийж, жолоочийн зарцуулсан шатахууныг жолоочийн тооцооны хуудсаар зардалд бүртгэх Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар -ын 4.5,б-д зааснаар Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн зарлага нь бараа материал худалдан авсан болон бусад байгууллага. хүмүүсээс авсан үйлчилгээний төлбөр байна гэснийг мөрдөж ажиллах</p>	<p>2015 оны эхний хагас жилийн байдлаар байгууллага хүмүүстэй холбоотой авлагын үлдэгдэл 8143.8 мянган төгрөгийг холбогдох газруудтай тооцоо нийлж, өмнөх онуудын үндсэн баримтуудыг хуулбарлан, зарим орлогод аваагүй хөрөнгийг орлогод авч, холбогдох баримтыг үндэслэн дараа тайлангийн тооцооны хаалтын бичилт хийсэн.</p> <p>2014 оны эцэст 7 байгууллага хүмүүстэй холбоотой 101 109.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.</p> <p>Жич: Нэмэлт төсвийн орлогын дансанд Санхүүгийн зохицуулах хороо, "Санхүүгийн хүртээмжийн холбоо" Оулсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан бага, дунд орлоготой</p>

малчдын санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх" төслийн санхүүжилтээр Герман улсаас шилжиж ирсэн он дамжин хэрэгжүүлэх төслийн урьдчилгаа 91 342.8 мянган төгрөгийг 2014 оны эцэст Сангийн яам улсын төсөвт татан төвлөрүүлснээс үүссэн авлагыг хасч тооцвол 6 байгууллагаас 9966.3 мянган төгрөгийн авлагатай байна.

Авлага бүхий 4 байгууллагатай тооцоо нийлсэн акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулсан. Арилжаа эрхлэгчдийн холбооноос авах 217.0 мянган төгрөгийн үлдэгдлийг 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

6	<p>Тайлант хугацаанд барилга байгууламж 175.1 сая төгрөг, Авто тээврийн хэрэгсэл 170.8 сая төгрөг нийт 345.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу тооцоолсон, ижил төстэй техник хэрэгслийг өөр өөр хугацаагаар элэгдэл байгуулсан. 0.7 сая төгрөгийн зурагтыг тоног төхөөрөмжийн дансанд, 0.4 сая төгрөгийн дугуй болон 2.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тавилга эд хогшлын дансанд тус тус буруу ангилан бүртгэсэн. Сангийн сайдын 2006 оны төсөвт байгууллагын НББ. санхүүгийн тайлангийн аргачлал, заавар дахь үндсэн хөрөнгийн ангиллын дагуу санхүүгийн программд оруулах.</p>	<p>Үндсэн хөрөнгийн бүлэг хоорондын гүйлгээг оны дундуур залруулга хийхэд урьд хийгдсэн бүх гүйлгээг элэгдлийн хамт устгаж дахин шивэхэд эхний хагас жилийн санхүүгийн тайланд өөрчлөлт орох тул Интер актив ХХК-тай ярилцан тохирч 2015 оны эхний үлдэгдлээр залруулга хийхээр болсон. Үндсэн хөрөнгийн бүлэг хооронд шилжүүлэх, зарим хөрөнгийг хангамжийн материалын данс руу шилжүүлэх хөрөнгийн жагсаалт гарган 2015 онд залруулга хийнэ.</p>
7	<p>Бусад үндсэн хөрөнгө дансанд дуусаагүй барилга 56.8 сая төгрөг, ном 2.5 сая төгрөг, дугуй 0.6 сая төгрөг, нийт 59.9 сая төгрөгийн элэгдлийн зардлыг тооцон бүртгэсэн байна. Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг дахин хянаж, бүртгэлд үнэн зөв тусгах. Алдааг залруулан тайлагнаж, ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам"-ыг мөрдөж ажиллах.</p>	<p>Тайлант онд бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй дуусаагүй барилга 56.8 сая төгрөг, ном 2.5 сая төгрөгийн элэгдлийг тус тус тооцоогүй.</p> <p>2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар тайлант онд элэгдэл тооцоогүй болон элэгдэл дутуу тооцсон хөрөнгийн элэгдлийг залруулан нэмж тооцоолсон.</p> <p>Үндсэн хөрөнгийн элэгдлийн нормыг дахин хянаж санхүүгийн тайланд үнэн зөв тусгах ажил хийгдсэн. Зарим үндсэн хөрөнгө элэгдлээ бүрэн нөхөж үлдэх өртөггүй байгаа тул элэгдлийн хувийг хэвээр үлдээсэн.</p> <p>Тавилга эд хогшилд бүртгэлтэй байсан 400.0 мянган төгрөгийн дугуйг хангамжийн материал дансанд шилжүүлэн бүртгэсэн.</p>

Ажлын албаны дарга

Ц.Энхбаяр

Ахлах референт

ам

И.Юмчиндул